



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/128

Улаанбаатар хот

Дүүргийн Онцгой комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох, ажиллах журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.3, 32.1.8 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/673 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг дүүргийн нутаг дэвсгэрт удирдан зохион байгуулах үүрэг бүхий Онцгой комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Онцгой комиссын шуурхай ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, комиссын ажиллах журмыг гуравдугаар, Мэргэжлийн ангийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Дүүргийн нутаг дэвсгэрт гарч болзошгүй аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослоос урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгохтой холбогдон гарах Онцгой комиссын хөрөнгө зардлыг тухайн жилийн Засаг даргын нөөц сангийн зардалд тусгахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Ц.Өсөхбаяр/-т үүрэг болгосугай.

3. Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг томилон тэдгээрийн гүйцэтгэх үүргийг тогтоож, бэлтгэл, бэлэн байдлыг хангаж ажиллахыг албадын дарга нарт, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж ажиллахыг Онцгой комиссын орлогч дарга, Онцгой байдлын хэлтсийн дарга Л.Цэрэндаваад үүрэг болгосугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2014 оны А/95 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВДАВАА